



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/457

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 42 дугаар зүйлийн 42.2.1.а, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Аймгийн 2019 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" 10 дугаар тогтоолын 2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд Их Сургууль байгуулагдсаны 40 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд тэмдэглэх Заяа бандид Намхайжанцын мэндэлсний 420 жилийн ойгоор босгох хөшөөний санхүүжилтийн эх үүсвэрт "Хөшөөт хөгжил сан"-гаас 10.0 сая төгрөг /Арван сая/-ийн дэмжлэг үзүүлэн зарцуулсугай.

2.Тус арга хэмжээний дэмжлэгийн санхүүжилтийн 10.0 сая төгрөгийг "Хөшөөт хөгжил сан"-гийн урьд оны үлдэгдлээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус, тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

